



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/610

Мөрөн сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулж  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.3 "а", 29.1.6-ийн "а", 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 46 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулах үйл ажиллагаа явуулахыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний 06:00 цагаас мөн оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

2. Аймгийн хэмжээнд урлаг соёлын үзвэр үйлчилгээ, болон олон нийтийг хамарсан арга хэмжээ, РС тоглоом, бүжгийн клуб, бильярд, спорт заал, фитнес, үсчин, гоо сайхны үйлчилгээ, баар, ил задгай барааны зах, сүм хийдийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний 06:00 цагаас мөн оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд зогсоосугай.

3. Авто засвар, авто угаалга, халуун ус, такси үйлчилгээ болон захиалгат хүргэлтээр үйлчлэх бараа, барилгын материалын дэлгүүр, цайны газар, рестораны үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан 2020 оны 12 дугаар сарын 01-ний 06:00 цагаас нээж ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

4. Хот хоорондын болон орон нутгийн авто замын хяналтын цэгийг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл үргэлжлүүлэн ажиллуулж, зорчиж буй иргэдийн хөдөлгөөнд бүртгэл хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэм сахиулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн төв, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх зохион байгуулалтыг хийж ажиллахыг байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

6. Тариалан сумын хяналтын цэгээр Улаанбаатар хот болон бусад аймгаас ирэх зорчигчдыг ялгаж, өөрсдийн сумдад нэгдсэн зохион байгуулалтаар хүргэх албан хаагчдыг томилон ирүүлж ажиллуулахыг Түнэл, Эрдэнэбулган Их-Уул, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Тосонцэнгэл сумдын Засаг дарга нарт даалгасугай.

7. Рашаант, Жаргалант сумдын авто замын хяналтын цэгийг хүч нэмэгдүүлэн 24 цагаар тасралтгүй ажиллуулж Архангай, Завхан аймгийн чиглэлээс зорчиж ирсэн

иргэдийн судалгааг аймгийн Онцгой комиссын шуурхай штабт тухай бүр ирүүлж ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД